



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 01216

Улаанбаатар хот

Төрийн алба хаасан хугацааны
нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрэм”-ийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн С.Ариунжаргалын төрийн албанд ажилласан хугацаа 310 сар болсон тул төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 25 хувиар, мэргэжилтэн Ч.Чулуунтөгсийн төрийн албанд ажилласан хугацаа 72 сар болсон тул төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5 хувиар, Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн мэргэжилтэн Я.Одгэрэлийн төрийн албанд ажилласан хугацаа 302 сар болсон тул төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 25 хувиар, өмч хувьчлал хариуцсан мэргэжилтэн М.Энхбаярын төрийн албанд ажилласан хугацаа 185 сар болсон тул төрийн албанд ажилласан хугацааны нэмэгдлийг 15 хувиар, Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн Б.Ганцоожийн төрийн алба хаасан хугацаа 121 сар болсон тул төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 10 хувиар тус тус бодож олгосугай.

2. Нэмэгдлийг албан хаагчдын албан тушаалын сарын үндсэн цалингаас бодож, 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн олгохыг Ерөнхий нягтлан бодогч /Н.Уранчимэг/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа санхүүгийн хэлтсийн дарга /А.Мөнгөн/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115050000533